



МИК ХОЛДИНГ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 3-р сарын 17 өдөр

№ 26/07

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 2 хэсэг, 65 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 1, 3, 4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдаж, 2021 оны 45 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 2, 9 дүгээр зүйлийн 7.11, 7.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 16/22 дугаартай тогтоолоор батлагдаж, 2021 оны 21/08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан “Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай журам”-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:
 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
 2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;
 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
 4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 1-р баталж, 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр болон мөн оны 4 дүгээр сарын 06-ны өдөр тус тус хоёроос доошгүй өдөр тутмын сонин болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 24-ний өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны

- компаниудаар дамжуулан хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж, танилцах бололцоогоор хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд даалгасугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Хашчулуун)-г томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
- Комиссын дарга: С.Амарсайхан, “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Хянан нийцүүлэлтийн газрын захирал;
- Гишүүн: Б.Тулга, “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Программ зохиогч;
О.Төгөлдөрхурц, “МИК Холдинг” ХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг хурлын дарга (Ч.Хашчулуун)-д даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт 3-р, санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр “Санал авах хуудас”-ны загварыг Хавсралт 4-р тус тус баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудсыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудаар дамжуулан хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд, хурлаар шийдвэрлэх асуудалд өгсөн саналыг 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 17:00 цаг хүртэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот хаягт байрлах компанийн байранд хүлээн авах болон түүнтэй бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Тооллогын комисст тус тус үүрэг болгосугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
14. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

